



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Аудитор: Ж.Назгүл
Утас: 99668909
Цахим хаяг:

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 18-ноос 2 дугаар сарын 21-ны хооронд хийхээр төлөвлөн, аудитор Ж.Назгүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-нд Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 18-нээс 2 дугаар сарын 21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 22-нд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Байгаль очныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор

нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны төсвийг Орон нутгийн төсвөөс аймгийн Төрийн сан дахь харилцах дансаар олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 29-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж гаргаагүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүү тооцоолох” ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 21 “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Орон нутгийн төсвөөс аймгийн Төрийн сан дах харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төсвийн захирагч нь 2017 онд 456.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 452.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1.6 сая төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 5.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, нийтдээ 462.7 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр төсөвөө 5.1 сая төгрөгөөр хэмнэж ажиллажээ. Оны эцэст батлагдсан төсвөөс 5.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзэхэд цалингийн зардал 68 хувь буюу 310.1 сая төгрөгийг, НДШ 7 хувь буюу 34.0 сая төгрөгийг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2 хувь буюу 10.2 сая төгрөгийг, хангамж бараа материалын зардал 1.1 хувь буюу 5.2 сая төгрөгийг, БГАҮТөлбөр 13 хувь буюу 60.0 сая төгрөгийг, 7 хувь буюу 32.6 сая төгрөгийг эзэлж байна.

Шилэн дансны мэдээлэл

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

ҮАГ-ын аудитын нэгдсэн төлөвлөгөөгөөр 2017 оны 11 дүгээр сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар 400.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Аудитын дүнгээр дутуу байршуулсан мэдээллийг бүрэн нөхөж мэдээллийн цахим хуудаст байршуулжээ. Шилэн дансны судалгааг shilendans гэсэн файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 29 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулав.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин, халаалт, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны онцлог гүйлгээний талаар тодруулбал:

Тайлант онд онцлохоор үйл явдал болоогүй байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг дараах алдаа зөрчил илэрэв. Үүнд:

1.Тайлант онд төсөвт төвлөрүүлсэн 5.0 сая төгрөгийг Төсвийн гүйцэтгэлийн тайланд буруу тайлагнаж Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: *Төсвийн гүйцэтгэлийн тайланд заларуулга хийв.*

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн. Үүнд:

2.Байгууллагын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байсан 6 ажилтанд Засгийн газраас олгосон 300000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулалыг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар “Урамшуулал олгох тухай” тэмдэглэл, УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: *Сахилгын шийтгэл хүлээсэн, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байхад олгосон урамшуулалын 1458000 төгрөгийг тухайн ажилчдаар нөхөн төлүүлээр акт тогтоов.*

1. БОАЖГазрын 2017 оны батлагдсан төсөвт Сангийн яам орон тооны хязгаарыг 41-ээр хянаж ирүүлсэн байна. Аймгийн Засаг даргын 2017 оны 2 дугаар сарын 09-ний А/61 дугаар захирамжаар орон тоог 42-оор, БОАЖГазрын даргын 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн А/06 дугаар тушаалаар орон тоог 41-ээр тус тус баталжээ.Гүйцэтгэлээр 44 орон тоог цалингийн сандаа багтаан ажиллуулж, орон тоог

Сангийн яамнаас хянасан хязгаараас 3-аар, захирамжаас 1-аар тус тус хэтрүүлэн ажиллуулсан байна.

Энэ нь УИХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоолын 3-ийн 1 дэх заалт, 2017 оны 29 дүгээр тогтоолын 1ийн 6 дах заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: *Аймгийн Засаг даргын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар асуудал тавихаар шийдвэрлэв.*

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа зөрчил гараагүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байгаа болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	М.ХУАНГАН	2018.02.21
АУДИТЫН МЕНЕЖЕР	Х.ЖЕНИСБЕК	2018.02.21
БЭЛТГЭСЭН: АУДИТОР	Ж.НАЗГҮЛ	2018.02.21